



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/77

Есөнбулаг сум

Тусгай зөвшөөрөл шинээр
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.9 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундааны худалдаанд тавигдах шаардлагыг хангаж, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авахаар материалаа ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг хавсралтаар шинээр олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хууль тогтоомж, шаардлага журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ЧИНБАТ

